

Шугам хоолой шаардлага хангаж байна уу?

2024 оны 5 сар



1-р зураг. Ү хэлбэрийн ширмэн шүүрийг гагнаастай ган хоолойд буруу угсарсан байдал



2-р зураг. Шүүрийн их биед том нүх гарсан байгаа нь.

Эх үүсвэр: CSB 2019-02-I-TX тайлан

Химийн бодисын уур дэгдэж, тэсэрснээс 1 ажилтан нас барж, 2 ажилтан хүнд, 28 ажилтан хөнгөн гэмтсэн. 3 инчийн (75 мм) Ү хэлбэрийн шүүр дулааны үйлчлэлээр тэлж, агшиж байсны улмаас гэнэт задарч 10,000 фунт (4500 кг) орчим хэмжээтэй шатамхай изобутилен алдагдсан. Энэ үеэр агаарт дэгдсэн уур тэсэрсэн.

Бид энэ удаагийн мэдээллээрээ үйлдвэрийн шугам хоолойд техникийн шаардлага хангасан материал, тоноглол ашиглах асуудлыг онцолж байна.

Шугам хоолой, тоноглолын зураг төсөлд хэд хэдэн алдаа гарсан нь тогтоогдсон. Ү хэлбэрийн шүүр, үл буцах хавхалга, гар ажиллагаатай хаалт зэргийг зураг төсөлд дүрслэн үзүүлээгүй байсан. Шугам хоолойг суурилуулах үед үйлдвэрийн процессын аюул эрсдэлийн үнэлгээ хийсэн бөгөөд осол болохоос жилийн өмнө дахин баталгаажуулсан байсан. Зураг төсөл нь газар дээрх угсралтаасаа өөр байгааг хэн ч анзаараагүй. Зураг төслөөр бол шугам хоолойг гагнаж, эсвэл 304 маркийн ган фланцаар холбож угсарсан байх ёстой. Гэтэл Ү хэлбэрийн 3 инчийн ширмэн шүүрийг ган хоолой дээр эрээсэн холболтоор угсарсан байсан. Салбарын стандартаар бол изобутилен дамжуулах хоолойд 3 инчийн эрээсэн холболт хийхийг хориглодог.

Цутгамал тоноглол, жишээ нь уг шүүр нь зэвэрдэггүй гантай харьцуулахад хэт хөшүүн тул амархан эвдэрдэг, улмаар салбарын хэд хэдэн стандартаар өндөр даралттай нүүрс-устөрөгчийн хоолойд ашиглахыг хориглосон байдаг.

Та мэдэх үү?

- Шугам хоолойн зураг төслийг салбарын албан ёсны стандартуудад нийцүүлэн боловсруулах. Уг стандартууд нь температур, даралт, материалын сонголт зэргийг зааж өгсөн байдаг.
- Ихэнх компаниуд үйлдвэрлэлийн процесс, хэрэглээний шингэний шугам хоолойн техникийн шаардлага боловсруулсан байдаг.
- Танай компани шугам хоолойн техникийн шаардлага боловсруулаагүй бол Үйлдвэрийн процессын арга туршлага (PIP), Америкийн механик инженерүүдийн холбоо (ASME), Европын хар төмөрлөг, гангийн стандартчиллын хороо (ECISS), Японы үйлдвэрийн стандартын хороо (JISC) зэрэг стандартуудыг авч ашиглаж болно.
- Эрээсэн холболтыг том диаметртэй, эрсдэлтэй материал дамжуулах шугам хоолойд ховорхон ашигладаг. Жижиг диаметртэй, хэмжилтийн болон дээжлэлтийн шугам хоолойд ашиглаж болно.
- Шугам хоолойн техникийн шаардлагаас гажих тохиолдол болгонд Өөрчлөлтийн менежментийн дагуу үнэлгээ хийж, техникийн багаар уг өөрчлөлтөд дүн шинжилгээ хийлгэнэ.
- Бүх шугам хоолойд Ажиллуулахын өмнөх аюулгүй ажиллагааны шалгалт хийж, техникийн шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлно.

Та юу хийх ёстой вэ?

- Шугам хоолой, тоноглолын зураг төсөлд процессын шугам хоолойг яг байгаа байдлаар нь нарийн дүрсэлсэн байна. Үгүй бол ахлах ажилтандаа нэн даруй мэдэгддэг байх хэрэгтэй.
- Үйлдвэрлэлийн аюул эрсдэлийн дүн шинжилгээний ажилтан судалгаа хийхийн өмнө шугам хоолой, тоноглолын зураг төслийг газар дээр нь шалгадаг байх нь оновчтой туршлага.
- 3/4 инч (19 мм)-ээс дээш диаметртэй, эрсдэлтэй материал дамжуулах шугам хоолойд эрээсэн холболт хийсэн байвал ахлах ажилтандаа мэдэгдэж шалгуулаарай.
- Шугам хоолойд өөрчлөлт хийх бол компанийн Өөрчлөлтийн менежментийн системийг ашиглаж, зохих шалгалтуудыг хийлгээрэй.

Танай компани шугам хоолойн техникийн шаардлагыг дагаж мөрдөж байна уу?